

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХИШИГ СУРГУУЛЬД ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

2019.10.12

Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг, Хишиг сургуулийн захиргаатай хамтран “Хичээлийн судалгааны арга зүй” сургалтыг 2019 оны 10 сарын 12 нд зохион байгуулж 23 багш хамрагдлаа. Сургалтыг Монголын хичээлийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Н.Оюунцэцэг, тус сургуулийн сургалтын менежер, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн гишүүн Л.Сувдаа нар удирдан явууллаа.

Газарзүйн багш М.Бержан 8 дугаар ангид “Цаг агаарын зураг унших” сэдвээр хичээл зохион байгуулж, бүх багш нар хэлэлцүүлэг хийж, хичээлийн судалгааны арга зүйг судаллаа.



Хичээл ажиглалтын явц



Хичээлд багш цахим үнэлгээг хэрэглэсэн нь шинэлэг бөгөөд багш нар хичээлдээ авч хэрэгжүүлэх боломжтой сайхан туршлага гарсаныг хэлэлцүүлгийн явцад дүгнэн ярилцлаа.



Хэлэлцүүлэгт бэлтгэж байгаа үе



Хэлэлцүүлгийг сургалтын менежер Л.Сувдаа удирдлаа. Хэлэлцүүлгийн явцад Н.Оюунцэцэг багш багш нарт анхаарах асуудлуудыг тухай бүрд хэлж зөвлөж, залруулж байсан нь энэ сургалтын давуу тал байлаа.



Манай сургуулийн хүсэлтийг хүлээн авч, бидэнд хичээлийн судалгааны арга зүйн талаар үнэтэй, үр дүнтэй сургалт зохион байгуулсан Н.Оюунцэцэг багшдаа баярлалаа. Бидний хамтын ажиллагааг улам өргөжих болтугай.

Хишиг сургуулийн захиргаа